

Оршил

Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших Чулуут цагаан дэл /ЧЦД/-ийн уурхай нь 1982 оноос ил уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж, олборлосон хүдрээс гар ялгалтын аргаар 75%-ийн CaF_2 агуулгатай жилд дунджаар 20000 тн бүхэллэг хайлуур жонш бэлтгэн экспортлодог.

“Монголчех металл” ХХК нь 2014, 2020 онуудад уул уурхайн зураг төсөл, судалгааны “Гложекс” ХХК-аар Чулуут цагаан дэлийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотгол хийлгэж, ЭБМЗ-өөр баталгаажуулсан.

Тус компани мөн 2021 онд тус компани ЧЦД-ийн уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ /БОНБНҮ/-ний тодотголыг баталгаажуулсан.

2021 онд тус компани хайлуур жоншны баяжуулах үйлдвэрээ барьж эхэлсэн бөгөөд 2023 оны 6 сард ашиглалтанд оруулж, туршилт хийж, он дуустал 97%-аас дээш агуулгатай 5000 тн флотацийн баяжмал гаргахаар төлөвлөж байна.

1. Төслийн ерөнхий мэдээлэл

<i>Төслийн нэр:</i>	“Чулуут цагаан дэл” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр байгуулах төсөл
<i>Төсөл хэрэгжүүлэгч:</i>	“Монголчех металл” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019009043, Регистрийн дугаар: 5051134, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-001105, MV-003284, MV-021065
<i>Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:</i>	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11р хороо, Дүнжингаравын гудамж, 48-2. Утас:70149003,
<i>Төслийн байршил:</i>	Чулуут цагаан дэлийн орд нь Улаанбаатар хотоос урагш 140 км, Төв аймгийн Баянцагаан сумын төвөөс зүүн хойшоо 24 км, төмөр замын Мааньт өртөөнөөс баруун тийш 50 км-т тус тус оршдог.
<i>Ашиглалтын технологи:</i>	Авто тээвэртэй ил уурхайн ашиглалтын технологи,


Төслийн хүчин чадал:

Жилд 200 мян.тн хайлуур жоншны хүдэр баяжуулах,

Төслийн үргэлжлэх хугацаа:

20 жил,

Чулуут цагаан дэлийн жоншны уурхайн байришил



Чулуут цагаан дэлийн хайлуур жоншны ордын нарийвчилсан хайгуулын ажлыг 1977-1980 онуудад дуусгаснаар 1980 онд анхны ТЭЗҮ-г боловсруулж, 1981-1982 онд техникийн проектыг боловсруулж, тэр үеийн “Монголчехословак-металл хамтарсан үйлдвэр”-ийн харьяанд Чулуут цагаан дэлийн уурхайг жилд 75000 тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар байгуулсан.

“Монголчехметалл” ХХК нь “Чулуут цагаан дэлийн хайлуур жоншны үйлдвэрийн шинэчлэл өргөтгөлийн ТЭЗҮ-ийг 2010 онд дахин боловсруулсан бөгөөд 2013 онд ордын хүдрийн 2, 5-р биетийн нөөцийг шинэчлэн тооцож батлуулсан.

АМГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 37, 38, 39 тоот тушаалаар Чулуут цагаан дэлийн ордын хайлуур жоншны хүдрийн нөөцийг бодитой (В) зэргээр 2,479.09 мян.тн, боломжтой (С) зэргээр 1,266.27 мян.тн, нийт 3,745.4 мян.тн-оор ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, ордын нийт нөөцөд тулгуурлан түүнийг ашиглах Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-н тодотголыг 2014 онд боловсруулж

баталгаажуулсан. ТЭЗҮ-ийн тодотголд ордыг жилийн 150.0 мян.тн хүчин чадлаар 20 жил ашиглахаар төлөвлөсөн. Ордын хаягдал бохирдлын тооцоог хүдрийн биет тус бүрт ашиглалтын түвшин бүрээр тооцоолоход бохирдол дунджаар 5.7 %, хаягдал дунджаар 3.8 % тооцсон.

Ил уурхайд хөрс хуулалт хүдэр олборлолтын ажилд өөрийн эзэмшлийн: АНУ-ын САТ 349Д, 329Д, 325Д, 320Д, 320С маркийн эксковаторууд, хөрс, хайлуур жоншны өрөмдлөгийн ажилд БНХАУ-ын JunJin үйлдвэрийн КУ-100 маркийн 90-110 мм диаметр бүхий хошуутай өрмийн машин, хөрс, хүдэр тээвэрт БНХАУ-ын “Синотрак” үйлдвэрийн 24 м³ тэвшний багтаамжтай, 30 тн даацтай HOWO ZZ3251N2941W маркийн автосамосвал, хөрсний овоолгод асгац түрэх, мөргөцөгт тэсэлгээгээр үүсэх нурлын хормой шуух ажилд АНУ-ын САТ D8 маркийн бульдозер, ачигч ZL-50, ZL-30 зэрэг тоног төхөөрөмжүүдийг ажиллуулдаг.

2020 онд Чулуут цагаан дэлийн ордыг ашиглах Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотголыг дахин боловсруулж баталгаажуулсан. 2020 онд Чулуут цагаан дэлийн ордын хүдрийн 3-р биетийн талбайд ашиглалтын хайгуул хийж, 253 мян тн хүдрийн нөөц тогтоож батлуулж, ТЭЗҮ-д тусгасан. Шинэ ТЭЗҮ-н тодотголд уурхайгаас жилд 180.0 мян.тонн хүдэр олборлон шинээр баригдах баяжуулах үйлдвэрийг хангахаар төлөвлөж байна. Олон жилийн ашиглалтын явцад хуримтлагдсан бага агуулгатай хүдрийг хуурай аргаар баяжуулах технологийг ОХУ-ын Екатеринбург хотын уулын институтэд хийсэн туршилтад үндэслэн сонгож, үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр тооцсон. Төсөлд жилд 50 мян.тонн хүдэр хуурай аргаар баяжуулж, 11 мян.тонн ФК-75 маркийн металлургийн жонш гаргахаар тусгаж байгаа.

2021 онд компани өөрийн хүч хөрөнгөөр уурхайг төвийн эрчим хүчинд холбож, Баяжуулах үйлдвэрийг барьж эхэлсэн. Тус үйлдвэрийг ажиллуулснаар 130 хүний шууд ажлын байр бий болгохын зэрэгцээ улс орон нутгийн төсөвт жил бүр 5.7-6.7 тэрбум төгрөг, 20 жилийн хугацаанд 145.4 тэрбум төгрөг оруулна.

2022 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл

ЧЦД -ийн уурхай 2022 онд уулын ажлын төлөвлөгөөгөөр хүдрийн 2, 3, 5-р биетүүдийн 1,2 га талбайд олборлолт явуулж, 1235.47 мян м3 хөрс хуулж, 164.52 мян тн хүдэр олборлож, өмнөх оны үлдэгдэл хүдэр 35.27 мян тн, нийт 199.79 мян тн хүдэр боловсруулж, 65-75%-ийн дундаж агуулгатай 47000 тн жонш, 35% агуулгатай хүдэр 50000 тн гаргаж ОХУ болон БНХАУ-д борлуулахаар тусгасан. Тус компани мөн 2022 онд 537 мян м3 хөрс хуулж, 170 мян тн хүдэр олборлож, 30 мян тн жонш гаргаад байна.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайгаас хүдэр олборлох, ачиж тээвэрлэх үед тоос босож хөрс, ургамал, орчныг дарах, ажиллагсад, ойр байгаа нутгийн иргэдийн амьсгалах агаар бохирдох тул тоосжилтын нөлөөллийг бууруулах зорилгоор 2022 онд дараах арга хэмжээг авсан:

1. ЧЦД уурхайгаас Мааньт дахь борлуулалтын хэсэг хүртэлх 48 км замыг хайрган хучилттай болгосон. Зам засварын ажлыг 5-р сарын 10-наас 8-р сарын 20-ны хооронд гүйцэтгэсэн бөгөөд энэ хугацаанд Зам гүүр барих тусгай зөвшөөрөл бүхий “Голын жим” ХХК-иар ажлыг гүйцэтгүүлсэн. 48км урттай, 8м өргөнтэй, 0.6м зузаан замыг 157800 м3 хайрга, шороог уурхайн талбайгаас болон орон нутгийн тодорхой газраас зөөж асгаж, түрж тэгшилж индүүдсэн. Мөн 8 м урттай, 240 мм-ийн диаметртай, 8 ширхэг трубаг замын трасс дагуу таарах 4 ш жалга, ус урсах газруудад ус зайлуулах шугам тавьсан. Дээрх зам засварын ажилд тус компани нийт **1400 сая** төгрөгийг зарцуулсан болно.

2. Уурхайн орчимд тоосжилтийг дарах зорилгоор гол замуудыг усалж байсан. Усны төлбөрт 4,08 сая төгрөг төлсөн.

3. Шинээр автозасварын газар барьж, техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж, мөн шинээр шатахуун түгээх станц барьж, талбайг нь бетондсоноор хөрс бохирдуулахаас сэргийлсэн. /эдгээр зардлыг уурхайн ашиглалтын зардалд тооцсон/

Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнд 2022 онд **1404,08 сая төгрөг** зарцуулсан.

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Төлөвлөгөө: 2022 оны батлагдсан уулын ажлын болон Байгаль орчны Менежментийн төлөвлөгөөнд Чулуут цагаан дэлийн уурхай хүдрийн 2-р биетийн өмнө

жилүүдэд ашигласан 1,5 га талбайд 450 мян м³ хөрс дүүргэж тэгшлэн, техникийн нөхөн сэргээлт, 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж, шимт хөрсөөр хучин бэлчээрийн ургамал тарьж ургуулахаар тусгасан.

2022 онд тус компани Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд уурхайн тусгай зөвшөөрлийнхөө талбайд 5000ш Улиас, Хайлаас, Шар хуайс зэрэг мод тарина. Мөн орон нутагт: аймагт 200ш мод, суманд 200ш модны суулгац тус тус хандивлана.

Орчны хяналт шинжилгээ: Уурхайн хөрсний тогтсон 2 цэгээс 1,1 ширхэг дээж, одоогоор унд ахуйд ашиглаж буй худгаас усны 1 дээж авч Геологийн төв лабораторид шинжилгээ хийлгэнэ.

ЧЦД-ын уурхайгаас Мааньт хүртэлх 48км бүтээгдэхүүн тээврийн замаас 5км-ыг хайрган хучилттай болгож, нийт замыг хусч, засварлана.

2022 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийт 338,7 сая төг/хяналтын хуудсаар 13,7 сая төг/ зарцуулна./Техникийн болон биологийн нөхөн сэргээлт, зам засах ажлын зардлууд уурхайн олборлолтын зардалд суусан/

2022 онд уулын ажлын төлөвлөгөөнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийт 112,5 сая төг зарцуулахаар тусагасан. /Овоолгоор хийх техникийн нөхөн сэргээлт, шимт хөрсний нөхөн сэргээлт, зам засах ажлын зардлууд уурхайн зардал/

Гүйцэтгэл: 2022 онд хүдрийн 2-р биетийн өмнө жилүүдэд ашигласан 1,5 га талбайд 450 мян м³ хөрс дүүргэж тэгшлэн, техникийн нөхөн сэргээлт, 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж, шимт хөрсөөр хучиж бэлчээрийн ургамал тарьж ургуулахаар бэлдсэн.

2022 онд тус компани Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд уурхайн тусгай зөвшөөрлийнхөө талбайд 3600ш Улиас, Хайлаас, Шар хуайс, Монгол Дагор зэрэг мод тарьсан, мөн Баян суманд 1400ш Улиас, Хайлаас мод, Баянцагаан суманд 500ш Улиас, Хайлаас мод тус тус тарьсан.

Орчны хяналт шинжилгээ: Уурхайн хөрсний тогтсон 2 цэгээс 1,1 ширхэг дээж, одоогоор унд ахуйд ашиглаж буй худгаас усны 2 дээж авч, ШУА-н Газар зүй, Гео экологийн хүрээлэнд шинжилгээ хийлгэсэн.

ЧЦД-ын уурхайгаас Мааньт хүртэлх 48км бүтээгдэхүүн тээврийн замыг хайрган хучилттай болгосон.

2022 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийт **1752,18** сая төг зарцуулсан. (2022 онд уулын ажлын төлөвлөгөөнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийн 112,5 сая төг зарцуулахаар тусагасан. /Овоолгоор хийх техникийн нөхөн сэргээлт, шимт хөрсний нөхөн сэргээлт, зам засах ажлын зардлууд уурхайн зардал/)

2022 онд уурхайн талбайд шинээр тэлэлт хийж хөрс хуулаагүй учраас шимт хөрс хуулж, шинээр тусгайлан гадаад овоолго байгуулаагүй.

Техникийн нөхөн сэргээлт:

Хүдрийн 2-р хүдрийн биетийн өмнө хэсэгт өмнө жилүүдэд ашигласан 1,5 га талбайд 450 мян м³ хөрс дүүргэж тэгшилж, техникийн нөхөн сэргээлт хийсэн. Талбайд уурхайн 2022 онд хуулсан 450 мян м³ хөрсийг зөөж хийж, тэгшилсэн ба мөн хажуу талд байсан 3 овоолгуудыг түрж, хийж тэгшилсэн. /эдгээр ажлын зардал 240 сая төг уурхайн олборлолтын зардалд суусан/

Биологийн нөхөн сэргээлт:

2-р биетийн 2 га талбайг хар шороон хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийж, ерхөг, царгас, согооворын үр суулгасан. Биологийн нөхөн сэргээлтэд **23 сая төгрөгийн** зардал гаргасан.

3. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд: 2022 онд тус компани Ерөнхийлөгчийн санаачилсан ”Тэрбум мод” төслийн хүрээнд уурхайн тусгай зөвшөөрлийнхөө талбайд 3600ш Улиас, Хайлаас, Шар хуайс, Монгол Дагор зэрэг мод тарьсан, мөн Баян суманд 1400ш Улиас, Хайлаас мод, Баянцагаан суманд 500ш Улиас, Хайлаас мод тус тус тарьсан. Баянцагаан сумын 1-р багийн 9 айлын өвөлжөө нүүлгэж бууц түрсэн. Сургууль, Цэцэрлэг,

Эмнэлгийн хүнсэнд 500 кг мах нийлүүлсэн. /эдгээр зардлыг уурхайн ашиглалтын зардалд тооцсон 10 сая төг/

2022 дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд нийт 4,8 сая төгрөг зарцуулсан.

Тэрбум мод хөтөлбөр

Уурхайн талбайд Улиас 1100ш, Хайлаас 2300ш, Шар хуайс 100ш, Монгол Дагор 100ш, нийт 3600ш мод тарьсан бөгөөд 2022 онд мод тарих ажилд 44,0 **сая төгрөг** зарцуулсан.

4. Хог хаягдлын менежментын тайлан

Уурхайн хатуу хаягдал болох хоосон чулуулгийг өмнө жилүүдэд олборлосон хоосон талбайд хийж, дүүргэж тэгшилж, техникийн нөхөн сэргээлтэнд ашигласан. Ахуйн хог хаягдлыг хогийн цэгт цуглуулж, ангилан ялгаж, цэвэрлэн шатааж, ариутгасан. Баяжуулах үйлдвэрийн кэмп шинээр барьж ашиглалтанд оруулсан. 120 ажилчин амьдрах 30 өрөөтэй, өрөө бүртээ дотор жорлон душтэй. 120 хүний зориулалттай гал тогоо, оффис ажилчдын байр барьж ашиглалтанд оруулсан бөгөөд 00, цэвэр бохирын асуудлыг шийдсэн, тусгай ёткомть суурилуулсан /эдгээр зардлыг уурхайн ашиглалтын зардалд тооцсон/ ба дүүрэх үед соруулан, сумын зөвшөөрөгдсөн цэгт хаяна. Хог хаягдлын төлбөрт орон нутагт 1,1 **сая төгрөг** төлсөн.

5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хөрсний 2 дээжинд ерөнхий болон бохирдол, хүнд металлын шинжилгээ хийлгэсэн. Уурхайн унд ахуйд ашиглаж байгаа худгаас усны 1 2 дээжинд шинжилгээ хийлгэсэн. ШУА-н Газарзүй, Гео экологийн хүрээлэнд Геологийн Төв Лабораторид шинжилгээнүүдийг хийлгэсэн бөгөөд хөрсний бохирдол хэвийн хэмжээнд, ус ундны усны эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа. Ашиглаж байгаа худагт тоолуур тавьж, баталгаажуулсан. Орчны хяналт шинжилгээнд 2022 онд **0,2 сая төгрөг** зарцуулсан.

6. Удирдлага зохион байгуулалт

ХАБЭА, БО-н орон тооны мэргэжилтэн авч ажиллуулж, ХАБЭА-н зөвлөн туслах үйлчилгээ авсан, БОТ, ХАБЭАТ, ГАБТ, ДХТ хууль журмуудын талаар 2 удаа сургалт явуулсан. Уурхайд орон тооны мэргэжлийн эмч ажиллуулж, ажилчдыг байнгын хэрэгцээт эм тариа, аптекаар үнэгүй хангаж, эмчилгээ хийх болсон. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлж ковидын шинжилгээний сорьц, хамгаалах хэрэгслүүд, эмийг хангалттай хэмжээгээр бэлтгэж, гаднаас ирсэн хүмүүсийг тусгаарлах байр, Ковид-19 туссан хүнийг тусгаарлах байр бэлтгэж, Шуурхай ажлын комисс томилж, цар тахал гарсан үед авах арга хэмжээний төлөвлөгөө баталж дагаж мөрдсөн. /эдгээр зардлыг 51 сая төг уурхайн ашиглалтын зардалд тооцсон/ Сум баг орон нутагт Хандив тусламжаар 22,0 сая төг өгсөн бөгөөд 2022 онд Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд **31,0** сая төг зарцуулсан.

7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах

Олборлолтын болон нөхөн сэргээлтийн ажлын тайланг орон нутгийн /сумын/ захиргаанд 10-р сард тайлагнасан. Багийн 5,8 сарын хуралд танилцуулсан. 11 дүгээр сард аймгийн нөхөн сэргээлтийг хүлээж авах комисс-г уурхайн талбайд танилцуулж, дүгнэлт гаргуулна.

Нөхөн сэргээлтэд зарцуулсан зардлын тайлан: 2022 онд ЧЦД уурхайн Менежментийн төлөвлөгөөнд байгаль орчин хамгаалах нөхөн сэргээлтийн ажилд 339,0 сая төг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2022 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийт **1752,18** сая төг зарцуулсан.

Үүнээс:

1. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнд **1405.08 сая төгрөг**, үүнээс Зам засварт **1400,0 сая төгрөг**,
2. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд **23,0 сая төгрөг**, техникийн н/с **240 сая төг**
3. Тэрбум мод хөтөлбөр мод тарихад **44,0 сая төгрөг**
4. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд **4,8 сая төгрөг**,

5. Хог хаягдлын зардалд **1,1 сая төгрөг**,
6. Орчны хяналт шинжилгээнд **0,2 сая төгрөг**.
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтад **31,0 сая төгрөг**
8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнахад **3,0 сая төгрөг** тус тус зарцуулсан.

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үзүүлэлтүүд	Гүйцэтгэсэн ажил	Хугацаа ба давтамж		Зардал /сая төг/	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
Тоосжилтын нөлөөллийг бууруулах	48км бүтээгдэхүүн тээврийн замыг хайрган хучилттай болгосон.	жилд	жилд		1400
Ус ашиглалтаас хамаарч усны нөөцөд өөрчлөлт орох	Гол замуудыг ажиллах хугацаандаа нийт 2 удаа 20 тн усаар усалсан	ТОГТМОЛ	ТОГТМОЛ		1
	Усны дүгнэлт гаргуулж, төлбөр төлсөн.	жилд	жилд	3,996	4,08
Дүн					1405,08
2. Нөхөн сэргээлт					
Техникийн нөхөн сэргээлт	2-р биетийн 1,5 га талбайд 450,0 мян м3 хөрс дүүргэж, тэгшилсэн.	жилд	жилд	220,0	240,0
	2-р биетийн овоолго хэлбэржүүлсэн				
Биологийн нөхөн сэргээлт	2-р биетийн 2 га талбайг шимт хөрсөөр хучин бэлчээрийн ургамал тариалахад бэлэн болгосон.	жилд	жилд	22.5	23

	Уурхайн талбайд 3600ш Улиас, Хайлаас, Шар хуайс, Монгол Дагор зэрэг мод тарьсан.	жилд	жилд	76,5	28,8
	Баян, Баянцагаан суманд 1900ш Улиас, Хайлаас мод тарьсан.	жилд	жилд	6,0	15,2
Дүн				325,0	307,0
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ					
	Уурхайн дэргэдэх моджуулалтын талбайд 100 ш Улиас мод тарьсан.	жилд	жилд	3,0	0,3
Дүйцүүлэх нөхөн сэргээлт	Баян, Баянцагаан суманд 1900ш Улиас, Хайлаас мод тарьсан.	400 мод	1900 мод		
	Өвөлжөө нүүлгэж бууц түрсэн				4,5
Дүн					4,8
4. Хог, хаягдлын менежмент					
Хог хаягдал	Хогийн цэг, бие засах газрыг ариутгаж байсан, хогны төлбөр төлсөн	жилд	жилд	0,3	1,1
5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр					
Усны түвшний өөрчлөлт, бохирдол	Ашиглалтын худгаас 2ш дээж авч шинжлүүлсэн	жилд	жилд	0,15	0,1
Хөрсний бохирдол, коли	Кемп, уурхайн гол зам орчимд ажиглалтын цэгээс 2ш дээж авч шинжлүүлсэн	жилд	жилд	0,25	0,1
Дүн				0,4	0,2
6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт					

Удирдлага зохион байгуулалтын талаар	ХАБЭА, БО-н мэргэжилтэн авч, зөвлөн туслах үйлчилгээ авсан, БОТ, ХАБЭАТ, ГАБТ, ДХТ хууль журмуудын талаар 2 удаа сургалт явуулсан,	жилд	жилд	3,0	7,0
	Мэргэжлийн эмч ажиллуулж, эм тариагаар хангасан	жилд	жилд		2,0
Баянцагаан сумтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээгээр	Хандив тусламж	жилд	жилд		22,0
	22 хүнийг ажлын байраар хангасан	жилд	жилд		
Дүн				3,0	31,0
7. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах					
Үйл ажиллагаа, төлөвлөгөө, тайлангаа тайлагнах	Аймгийн холбогдох газрууд, Баянцагаан сум, 2-р баг	Жилд 2 удаа	5,8,11 сард		3,0
2022 онд Байгаль орчны менежментийн зардалд Нийт				339,0	1752,18

2022 оны мод тарих ажил











Хүдэр тээврийн зам засвар





Хяналтын цэгүүдээс дээж авч байгаа нь /5-р биет гол замын хажууд. цэг №1/



Хяналтын цэгүүдээс дээж авч байгаа нь /уурхайн кемпийн хаалганы хажууд. цэг №2/



2-р биет техникийн нөхөн сэргээлт





2-р биет техникийн нөхөн сэргээлт





2-р биет техникийн нөхөн сэргээлт





Дүйцүүлэн хамгаалах талбайд 100 ш Улиас мод тарив



**УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хянасан огноо	Шинжээч бөглөнө
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	Шинжээч бөглөнө
Дүгнэлт <ul style="list-style-type: none"> • Шийдвэрийн төсөл • Ололт, амжилттай тал • Дутагдалтай сул тал • Шаардлага 	Шинжээч бөглөнө

**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЭЛЭЛ**

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
 - Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.
 - 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Монголчехметалл” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011320147
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Ашигт малтмалын хайгуул ашиглалт, гадаад худалдаа
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11р хороо, Дүнжингаравын гудамж, 48-2. Утас:70149003,

	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б.Далай, 99112164
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	О.Туул, 86067745, tuul29@yahoo.com
1.2	1. Төслийн нэр	Чулуут цагаан дэлийн уурхай
	1. Төслийн харьяаллын байршил	Төв аймаг Баянцагаан сум
	3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд в. баяжуулах үйлдвэр	Хайлуур жонш Ил уурхай
	4. Төсөл эхэлсэн огноо	1980
	5. Төсөл хэрэгжих хугацаа	70
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	2035
	7. Хаалтын дараах зориулалт	Багийн төв
	8. ТЭЗҮ баталсан огноо	1980, 2010, 2014, 2020
	9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	10 мян.тн
	10. Ажилчдын тоо	96
	11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	47 мян.тн
	12. Тухайн төсөлд хамраах дэд бүтэц • замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл; • шатахуун түгээгүүрийн тоо • шатахуун агуулахын агууламжийн хэмжээ • тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	48 км, Мааньт - ЧЦД уурхай 1 20 тн 15 тн

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	Хайлуур жонш 1105А 2037 он хүртэл 104,47 га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	ашигладаггүй
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	-
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2021.04.04 № 0003247
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2021.03.09 БОАЖЯ
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2021.07.08 БОАЖЯ
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2022.03.17 (07/68)
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2022.02.25
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах	+

10. Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-гаар/	Тайлант онд гүйцэтгэсэн	1,5
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	1,5
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-гаар	Тайлант онд гүйцэтгэсэн	2,0
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	2,0
11. ТХГН-ын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах			+
12. Тухайн жилд баримтлах стандартын дугаар <ul style="list-style-type: none"> • Үндэсний • Олон улсын 			

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

• Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрын А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтанд тусгагдсанг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах

• Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/

• Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “**хангалттай**” гэсэн дүгнэлтийг оруулна.

• Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	-
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ашиглахгүй
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Дизель түлш 20 тн-ы агуулах
	2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Анфо 15 тн-ы агуулах
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/	тн
	<ul style="list-style-type: none"> • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал 	30 -
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	1,1 сая төг

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

- Доорх хүснэгтийн 4.1.2 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт төсөв	1752,18 сая төг нийт төсөв
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	1,3
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1405,08
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	307
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	4,8
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	3,0
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	31,0
	8. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-
	9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт зарцуулсан нийт зардал /сая төг/	1752,18

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

• Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

• Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	<p>Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл</p> <ol style="list-style-type: none"> 1. Тосгон 2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 3. Хог хаягдлын цэгийн байршил 4. Хог хаягдлын агуулахын байршил 5. Хог хаягдлын далан 6. Химийн бодисын агуулахын байршил 7. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 8. Тухайн жилд хуулах хөрс 9. Гадаад, дотоод овоолго 10. Техникийн нөхөн сэргээлтийн талбай 11. Биологийн нөхөн сэргээлтийн талбай 12. Гүний худгийн байршил 13. Дүйцүүлэн хамгааллын байршил 	

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

• Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “**тодорхойлсон**”, “**тодорхойлоогүй**” “**хамааралгүй**” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.

• Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт БОНХЯ-ны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

✓ - **тодорхойлсон гэсэн тэмдэглэгээ**

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
- Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	✓	✓	✓	✓	
- Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	✓	✓	✓	✓	
- Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах	тодорхойлоогүй хамгааралгүй				
- Агаарт үзүүлэх нөлөөлөл Бохирдуулах - тоос	✓	✓	✓	✓	
- Түүх соёлын дурсгалт эд зүйлс - Хамгаалах - Нүүлгэн шилжүүлэх	хамгааралгүй				

ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнгүүд “хангалттай” “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	1,3	тийм	тийм	
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	1405,08	тийм	тийм	
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн/га эзэлхүүн - биологийн /га	1,5 /450 мм3 2,0	тийм	тийм	
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	1900 мод	тийм	тийм	
7.5. 7.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	3,0	тийм	тийм	
7.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-	үгүй	үгүй	
7.7. БОМ-ийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	31,0	тийм	тийм	

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ**ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” баганд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв
8.1. Хөрс	2	Уурхайн гол зам Кемп	1	100,000
8.2. Ус	2	Худаг	1	100,000
8.3. Амьтан	-	-	-	-
8.4. Ургамал	-	-	-	-
8.5. Агаар	-	-	-	-